



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2013 оны 10 дугаар сарын 23

Дугаар 410

Улаанбаатар хот

**“Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах
зөвшөөрлийн журам” батлах тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 15.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. “Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Энэ тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж шийдвэрлэн, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

Санхүүгийн зохицуулаа хорооны 2013 оны 10 дугаар сарын 23-ны өдрийн 410 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ДААТГАГЧТАЙ ДААТГАЛЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРЛИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын иргэн, эсхүл Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5, 5.1.6 дахь хэсэгт заасан Монгол Улсад хувийн болон албан хэргээр оршин суугч хувь хүн, Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд, гадаадын хуулийн этгээдийн салбар, төлөөлөгчийн газар /цаашид “Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд” гэх/ нь өөрийн эд хөрөнгө, ашиг сонирхлоо даатгуулах зорилгоор Даатгалын тухай хуулийн 17.2 дахь заалтын дагуу гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооноос /цаашид “Хороо” гэх/ олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2. Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд нь гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийг Хорооноос авсны үндсэн дээр Монгол Улсын даатгалын зуучлагчаар дамжуулж, эсхүл өөрөө шууд гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулж болно.

1.3. Монгол Улсад 90 хүртэл хоногоор зорчиж байгаа буюу түр хугацаагаар оршин суугчид энэ журам үйлчлэхгүй.

Хоёр. Хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичиг

2.1. Монгол Улсад оршин суугч хувь хүн, хуулийн этгээд гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл хүсэхдээ дараах баримт бичгийг бүрдүүлж Хороонд ирүүлнэ:

2.1.1. Энэ журмын хавсралт “Маягт-1”-ийн дагуу гаргасан хүсэлт /Хэрэв даатгалын зуучлагчаар дамжуулан даатгуулах бол Монгол Улсын даатгалын зуучлагч компанийн оноосон нэрийг хүсэлтэд нөхөж бичнэ/;

2.1.2. Монгол Улсын иргэн бол иргэний үнэмлэхний, Монгол Улсад хувийн болон албан хэргээр оршин суугч хувь хүн бол гадаад паспорт болон Гадаадын иргэдийн асуудал эрхлэх эрх бүхий байгууллагаас олгосон оршин суух эрхийн баримт бичиг, Хуулийн этгээд, салбар, төлөөлөгчийн газар бол улсын бүртгэлийн гэрчилгээний гэрчлүүлсэн хуулбарыг тус тус;

2.1.3. Байгуулах даатгалын гэрээний төсөл;

2.1.4. Энэ журмын хавсралт “Маягт-2”-ын дагуу гаргасан, тухайн даатгалын хэлбэр, бүтээгдэхүүний зөвшөөрөлтэй, эрсдэлээ давхар даатгуулах туршлага бүхий Монгол Улсын даатгалын 3-аас доошгүй компаниас уг эрсдэлийг даатгах боломжгүй, эсхүл зөвхөн хамтарсан хэлбэрээр даатгах боломжтой гэсэн тодорхойлолт;

2.1.5. Гадаадын даатгагчийн талаарх Хорооноос шаардсан мэдээлэл.

Гурав. Хүсэлтийг шийдвэрлэх

3.1. Даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл олгохыг хүсч ирүүлсэн өргөдөл, баримт бичгийг Даатгалын газар ажлын 15 хоногийн дотор Даатгалын тухай хууль тогтоомжийн дагуу хянаж шийдвэрлэнэ.

3.2. Танилцуулгад дараах мэдээллийг тусгасан байна:

3.2.1. Хүсэлт гаргагчийн даатгалд хамруулах эрсдэлийг Монгол Улсын даатгалын компани даатгах боломжгүй талаарх мэдээлэл;

3.2.2. Гадаадын даатгагчийн төлбөрийн чадвар, ашигт ажиллагааны үзүүлэлтүүд, үнэлгээний компанийн тогтоосон зэрэглэл;

3.2.3. Гадаадын даатгагчийн тухайн даатгалын эрсдэлийг хариуцах дадлага, туршлага зэрэг болно.

3.3. Даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гарснаас хойш ажлын 3 хоногт багтаан Даатгалын газар хүсэлт гаргагчид албан бичгээр мэдэгдэх бөгөөд хэрэв зөвшөөрөөгүй тохиолдолд үндэслэлээ тусгана.

3.4. Энэ журмын 2.2.4-т заасан тодорхойлолт авах хүсэлтийг даатгагчдад хүргүүлснээс хойш даатгалын компани 3 хоногийн дотор хариуг албан бичгээр өгнө.

3.5. Дээрх хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр шийдвэрлээгүй, хариу өгөөгүй бол даатгалын компанийг тухайн эрсдэлийг даатгахаас татгалзсан гэж үзнэ. Энэ тохиолдолд өргөдөл гаргагчаас даатгалын компанид хүргүүлсэн хүсэлтийн хувийг Хороонд ирүүлж болно.

3.6. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.5, 5.1.6 дахь хэсэгт заасан Монгол Улсад хувийн болон албан хэргээр оршин суугч хувь хүн нь Монгол Улсад ирэхээс өмнө даатгалд хамрагдсан тохиолдолд тухайн даатгалын гэрээний хугацааг дууссаны дараа энэ журмын дагуу даатгалд хамрагдана.

Дөрөв. Хяналт тавих

4.1. Хороо нь энэ журмын биелэлтэд хяналт тавих бөгөөд энэхүү журмыг зөрчсөн этгээдэд Даатгалын тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

“Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам”-ын хавсралт “Маягт-1”

ГАДААДЫН ДААТГАГЧТАЙ ДААТГАЛЫН ГЭРЭЭ
БАЙГУУЛАХ ЗӨВШӨӨРӨЛ ХҮССЭН ӨРГӨДӨЛ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IY байр,

Бага тойруу-6, Улаанбаатар-46,

Монгол улс

Хэнээс:

.....
(өргөдөл гаргагчийн овог нэр/хуулийн этгээдийн оноосон нэр/, хаяг, утас, факс, и-мэйл хаяг)

Иргэн, Хуулийн этгээднь дор дурдсан даатгалын хэлбэрт хамаарах даатгалын гэрээг гадаадын даатгагч болох “.....” /нэр/-тай /эсхүл даатгалын зуучлагч болох “.....” ХХК-иар дамжуулан/ байгуулахаар шийдвэрлэсэн болно.

Үүнд дараах хэлбэрүүд хамаарна:

1.....

2.....

3.....

Монгол Улсын Даатгалын тухай хууль, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан “Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам”-д нийцүүлэн гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл авахад шаардагдах баримт бичгийг үнэн зөв бүрдүүлж хүргүүлэв.

Бүрдүүлсэн баримт бичигт хуурамч, худал ташаа зүйл орсон байвал хариуцлагыг манай байгууллага, би хүлээх болно.

Манай байгууллагын, Миний өргөдөл материалыг хүлээн авч, хянан шийдвэрлэж, гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрөл олгож өгнө үү.

ӨРГӨДӨЛ ГАРГАГЧ:

.....

(гарын үсэг)

(овог, нэр)

“Гадаадын даатгагчтай даатгалын гэрээ байгуулах зөвшөөрлийн журам”-ын хавсралт “Маягт-2”

“..... ДААТГАЛ” ХХК-ИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Огноо:

Хаана: Санхүүгийн зохицуулах хороо,

Засгийн газрын IY байр,

Бага тойруу-6, Улаанбаатар-46,

Монгол улс

Иргэн, Хуулийн этгээдний дор дурдсан даатгалын хэлбэрт хамаарах эрсдэлийг манай компани даатгах боломжгүй /эсхүл гадаадын даатгагчтай хамтран даатгалд хамруулах боломжтой/ болохыг тодорхойлов.

Үүнд дараах хэлбэрүүд хамаарна:

- 1.....
- 2.....
- 3.....

Компанийн гүйцэтгэх захирал:

.....
(гарын үсэг) (овог, нэр)